



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа  
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны I сар)

## ГАРЧИГ

<b>БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ I САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....</b>	<b>3</b>
---	----------

<b>1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>3</b>
---	----------

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил.....	3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ .....	3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ .....	4
1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ .....	5
1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ .....	5
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр) .....	6
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо .....	6
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт .....	6
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт .....	7

<b>2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>9</b>
--	----------

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ .....	9
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил .....	9
2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ .....	9
2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр).....	10

<b>3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>11</b>
--	-----------

## **БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ I САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны I сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

### **1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

(Тайлант хугацаа 2025.12.05 - 2026.01.05)

#### **1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **210** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 15,078,720 вон, нутаг буцах зардал: 2,572,320 вон, ажил олгогчоос олгох 13 дахь сарын цалин: 25,350,828 вон, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү 10,452,198 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 5,161,000 вон, ажил олгогчоос нэхэмжилсэн 13 дахь сарын цалин: 7,491,480 вон зэрэг хэлбэрээр нийт **51,027,826** воныг Монгол Улсын **14** иргэнд олгуулав.

##### **1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ**

- Иргэн Б.С (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 3,249,702 вон, нутаг буцах зардал 500,000 воныг олгуулав.

- Иргэн М.Б-д (Е-9) 13 дахь сарын цалин 5,476,588 вон, нутаг буцах зардал 523,500 вон, нийт 6,000,088 воныг олгуулсан.
- Иргэн Б.А-д (Е-9) 13 дахь сарын цалин 3,250,000, нутаг буцах зардал 511,000 вон, нийт 3,761,000 воныг олгуулав.
- Иргэн Д.Т-гийн (Е-9) 13 дахь сарын цалин болон нутаг буцах зардлын баримтыг бүрдүүлж Самсунг даатгал руу илгээн 8,804,398 воныг олгуулсан.
- Иргэн Б.Д-гийн (Е-7-4) 13 дахь сарын цалинг ажил олгогчоос нэхэмжлэн 8,652,198 воныг олгуулсан.
- Иргэн Б.Б-гийн (Е-7-4) нутаг буцах замын зардал 537,820 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Н.Б-гийн (Е-9) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалинг Үжинбүгийн хөдөлмөрийн хэлтэст илгээн, 12-р сарын 29-нд томилогдсон байцаагч болон ажил олгогчтой уулзаж тохиролцооноор 1,800,000 воныг олгуулсан.
- Иргэн А.У-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг Хөдөлмөрийн хэлтэст (고용노동부 총주지청) хүргүүлэв.
- Иргэн Г.Д-гийн (визгүй) 13 дахь сарын цалин олгуулах хүсэлтийг хүлээн авч тооцооллыг хийн 2025.12.24-ний өдөр 영월출장소-д өргөдлийг хүргүүлэв.
- Иргэн Л.Б-гийн (Е-8) илүү цагийн хөлс олгох тооцооллыг хийсэн.
- Иргэн А.А-гийн (визгүй) нөхөн олговрыг олгуулах асуудлаар Хөдөлмөр халамжийн хэрэг эрхлэх газраас ирүүлсэн цагийн тооцоолол болон ослын үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг бүрдүүлж, 2025.12.15-ны өдөр хүргүүлэв.
- Иргэн Ц.Н, П.Э нарын (визгүй) 13 дахь сарын цалин нэхэмжилсэн өргөдлийг Хөдөлмөрийн хэлтэст (성남지청) шуудангаар хүргүүлсэн. Өргөдөл гаргагчийг 2 удаа дуудсан ч очоогүй тул өргөдлийг хаасан.

#### **1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ**

- Иргэн П.О-гийн (визгүй) 2025 оны 6, 7, 8 дугаар сард 26 хоног барилгад ажиллаад авч чадаагүй цалинг нэхэмжилж, ажил олгогчтой холбогдон цалингийн эхний барагдуулалт 2,000,000 воныг олгуулсан.
- Иргэн Ц.Г (визгүй) 13 дахь сарын цалингийн асуудлаар Хөдөлмөрийн хэлтэст (서울동부고용노동청)-т өргөдөл гаргаж, 2,690,000 воныг дансанд нь олгуулсан.
- Иргэн Б.Т (визгүй), Б.Н (визгүй), С.Э (визгүй), О.Б (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- Иргэн С.Г-гийн (G-1) олгогдоогүй цалингийн үлдэгдэл 1,500,000 вон нэхэмжилсэн өргөдлийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
- Иргэн Б.Б-гийн (визгүй) үйлдвэрийн 13 дахь сарын цалин 5,231,699 воныг олгуулахаар Хөдөлмөрийн хэлтэс (소원고용노동부지청)-т өргөдөл гаргасан.
- Иргэн Л.О-гийн (визгүй) 2024.07.22–2024.07.28-ныг хүртэл ажилласан хугацаанд авч чадаагүй цалин 660,000 воныг 2025.12.12-ны өдөр олгуулав.

- Иргэн Б.П (визгүй) нь Монгол Улс руу буцсан бөгөөд авч чадаагүй цалин 2,501,000 вон, 13 дахь сарын цалин 4,801,480 вонг тус тус 2025.12.19-ны өдөр олгуулсан.

### **1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ**

БНСУ дахь 제한몽골학교 (Монгол) сургуулийн 310 сурагчид ерөнхий боловсролын шинээр хэвлэгдсэн сурах бичгийг “Сайн учрал” сантай хамтран 2026.01.05-ны өдөр гардуулж өгсөн.

Монгол хэл бичгийн төвтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2025 онд Монгол хэл бичгээ суралцаж эхэлсэн хүүхдүүдийн Эрдмийн баярыг 2025.12.14-ны өдөр хамтран зохион байгуулсан. Эрдмийн баярт 80 иргэн оролцсон.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд БНСУ-д оршин сууж буй сургууль завсардсан хүүхдүүдэд зохион байгуулах сургалтад шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийг хийлгэж, хүүхдүүд, эцэг эхчүүдийг тус газрын мэргэжилтэн Л.Алтанхишигтэй уулзуулж, зөвлөгөө мэдээлэл хүргүүлж ажиллав.

### **1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз рүү шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 9 иргэнийг, E-7-4 виз рүү шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 2 иргэнийг шинээр бүртгэсэн.
- E-7-4 визний асуудлаар нийт 21 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Хөдөлмөрийн гэрээний E-9 визээс E-7-4 визний ангилал руу шилжихээр өргөдөл гаргасан А.Э-гийн өргөдлийг хүлээн авч оноо тоолж, визний шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, анхаарах асуудлын талаар зөвлөн, ажил олгогчтой нь холбогдож орчуулга хийж, баримт бичгийг нь хянах зэргээр дэмжлэг үзүүлж 2025.12.16-ны өдөр визийг нь мэдүүлсэн. Мөн тус төвөөс дэмжиж 2025.12.03-ны өдөр виз мэдүүлсэн иргэн Ц.Б-гийн виз зөвшөөрөгдөж, 2025.01.05-ны өдөр визний ангиллаа сольсон.
- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа бөгөөд гишүүдийн тоо 794 хүрээд байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд 6 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

## 1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

### 1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

	Тоон мэдээллийн агуулга	Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1) Нутаг буцах зардал	5	2,575,320
	2) Цалин, илүү цагийн хөлс		
	3) Самсунгийн 13 дахь сарын цалин	5	25,350,828
	4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	1	10,452,198
	5) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6) Гэнэтийн ослын даатгал		
	7) Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс		
	10) 13 дахь сарын цалин		
	11) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	3	5,161,000
	14) 13 дахь сарын цалин	2	7,491,480
	15) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
<b>Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн</b>		<b>14</b>	<b>51,027,826</b>

### 1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
47	14	16	14	-	31

### 1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээ	Тоо
1) Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	12
2) Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	3
3) Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлүүлэх	7
4) Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	20
5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	1
6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	3
7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	1
8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх	5
9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	
10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга	29
11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх	7
12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх	
13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх	
14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	6
15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих	21
16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	32

17) Бусад мэдээлэл, зөвлөгөө		39
18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх		24
	Утсаар	145
	Цахимаар	28
Хүргэсэн үйлчилгээний тоо	Танхимаар	37
	<b>Нийт</b>	<b>210</b>

## **2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

(Тайлан хамарсан хугацаа 2026.01.01 - 2026.01.31)

### **2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ**

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 90 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 26 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 2 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 88 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 116 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 69 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 40 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 5 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 39 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 84 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үйлчилсэн.

### **2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил**

Тайлант хугацаанд тус тасаг 285,522,286.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 62 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 115,008,587.71 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 01 дүгээр сард нийт 58 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 51,627,490.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 31 даатгуулагчийн 36,383,100.00 төгрөг, сайн дурын даатгалын 27 даатгуулагчийн 15,244,390.00 төгрөг байна.

### **2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ**

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа

зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас, цахим, танхимаар нийт 785 иргэн, даатгуулагчид үйлчилгээг үзүүлсэн.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 1 ээлжийн 3 иргэний 19,428,780.00 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.

БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголт хэр зэрэг байгааг танин мэдэх зорилгоор 17 иргэнээс судалгаа авсан.

#### 2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ		Тоо	Өссөн дүнгээр
1. Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	90	90
	Сайн дурын даатгал	84	84
2. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	Шинээр	88	88
	Дахин	2	2
	Хугацаа сунгасан	26	26
3. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	Шинээр	39	39
	Дахин	5	5
	Хугацаа сунгасан	40	40
4. Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	96,725,200.00	96,725,200.00
		<b>37%</b>	<b>37%</b>
	Сайн дурын даатгал	188,797,086.00	188,797,086.00
		<b>93%</b>	<b>93%</b>
	Нийт	285,522,286.00	285,522,286.00
		<b>62%</b>	<b>62%</b>
5. Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	36,383,100.00	36,383,100.00
	Сайн дур	15,244,390.00	15,244,390.00
6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	19,428,780.00	19,428,780.00
	Олгосон	0	0
	Буцаан олголт авсан хүний тоо	0	0
7. Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	444	444
	Цахимаар	70	70
	Танхимаар	61	61

### 3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 22, youtube сувагт 9, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 12 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 573,153 хандалт авсан. Төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн <https://control.e-mongolia.mn/auth/login> веб сайтад 215 мэдээлэл байршуулсан.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 31 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2025.12.12-ны өдөр цахимаар, ирсний дараах сургалтыг 2025.12.18-ны өдөр 9 иргэнийг хамруулан Ичоны сургалтын төвд, 25 иргэнийг хамруулан Ёжүгийн сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга;
- Цалин хөлс тооцох, ажлын байр солихтой холбоотой хууль, дүрэм, журам;
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай;
- Монгол Улсын нийгмийн даатгалын холбогдох хууль тогтоомж;
- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн тухай хууль;
- “Нийгмийн хамгааллын тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн тухай;
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай;
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйлс;
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл;
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний тухай;
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь;
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Тайлант хугацаанд 29 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийг тусламж үйлчилгээ авч буй асуудлаар нь ангилж үзвэл: сэтгэл гутралын асуудалтай 4, сэтгэл түгшилттэй 2, гэр бүлийн асуудалтай 2, бусад шалтгаантай 21 иргэн байна.

2025 оны 12 сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 29 иргэнд нойргүйдэл илрүүлэх сорил, сэтгэл гутралын болон сэтгэл түгшилтийн сорил хийж, дүгнэлт гаргав. Үүнд:

- Нойргүйдэл илэрсэн 18 иргэн, үүнээс 20-29 насны 7 иргэн, 30-39 насны 11 иргэн байна.
- Сэтгэл гутралын завсрын байдалтай 4 иргэн, үүнээс 20-29 насны 1 иргэн, 30-39 насны 3 иргэн байна.
- Сэтгэл түгшилтийн завсрын байдалтай 9 иргэн, үүнээс 20-29 насны 3 иргэн 30-39 насны 6 иргэн байна.

Төвийн албан хаагчид 2026.01.14-ний өдөр Ичон хот дахь сургалтын төвд E-9 визээр ирсэн 8 хөдөлмөрийн гэрээт ажилтанд ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж ажиллав.

2026.01.17-ны өдөр БНСУ дахь Монгол Эмэгтэйчүүдийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан зохиолч Б.Ариунаагийн “Жигүүр ургуулж өгсөн тэр минь” солонгос хэлээрх номын нээлтийн үеэр явуулын үйлчилгээг хүргэж, 9 иргэнд нийгмийн даатгалын хуулийг танилцуулж, тэтгэврийн нас хүрэх болон хүрсэн 5 иргэний ажилласан жил, шимтгэл төлөлтийг шалгаж, бусад холбогдох зөвлөгөөг өгч, мэдээлэл хүргэж ажиллав.

2026.01.23-ны өдөр төвийн албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим мэдээллийн цагийн хөтөлбөрт оролцож, “Хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголт” сэдвээр мэдээлэл авсан.

2026.01.24-ний өдөр Сөүл хотын “Seoul Jump Medical Center” болон БНСУ-ын “Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын нэгдсэн холбоо” ТББ-тай хамтран нийгмийн хамгааллын чиглэлээр эрүүл мэндийн анхан шатны үзлэг, оношилгоог зохион байгуулж ажилласан, 13 иргэн хамрагдсан.

2026.01.31-ний өдөр Чонжү хотын “Баянмонгол” ресторанд “Нэг цонхны үйлчилгээ”-нд явуулын үйлчилгээг хүргэж ажилласан, 60 иргэн оролцсон.

--- оОо ---